



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/165

Есенбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны "Аймгийн 2026 оны төсөвт зохицуулалт хийх тухай" 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Цогт сумын Баянтоорой тосгоны цэцэрлэгийн гадна, дотор цэвэр усны холболт, бохирын шугам септик хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Д.Чинзориг	(Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
	Ч.Ууганбаяр	(Хөндлөнгийн төлөөлөл)
	Ж.Мөнхцэцэг	(тохиролцсон)
		(Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)
		(тохиролцсон)
Нарийн бичиг:	Д.Нарандулам	(Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Чинзориг)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

